

**БАТЛАВ.**

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**

**Б.ЭНХБАЯР**

## **ГЭРИЙН ТЭЖЭЭВЭР АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

### **1.1. Хууль зүйн үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.” гэж заасан.

Монгол Улсад мал, гэрийн тэжээвэр амьтнаас бусад амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, түүний нөөцийг зохистой ашиглахтай холбоотой харилцааг Амьтны тухай хуулиар, мал, тэжээвэр амьтан (гахай, тахиа зэрэг ашиг шимийг нь ашиглахаар үржүүлж байгаа амьтан), зэрлэг амьтны эрүүл мэндийг хамгаалах, тэдгээрийн түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулиар тус тус зохицуулж байна. Харин гэрийн тэжээвэр амьтан буюу нохой, муур, тэдгээртэй адилтгах бусад амьтантай холбогдох асуудал одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжоор зохицуулагдаагүй үлджээ.

Дэлхийн 124 орон нохой, муур, тэдгээртэй адилтгах гэрийн тэжээвэр амьтныг хүчирхийллээс хамгаалах, хяналттайгаар үржүүлэх, бүртгэх, худалдах, худалдан авахтай холбоотой харилцааг зохицуулсан хуультай байна. Дэлхийн амьтан хамгаалах нийгэмлэг (World Animal Protection)-ээс амьтныг хамгаалах хууль тогтоомж, бодлогын дагуу 50 улсыг хамруулсан Амьтан хамгаалах индекс (API)-ийг гаргадаг байна. Энэхүү индексээр 50 улс орон тус бүрийг 4 зорилтоор бүлэглэн 10 үзүүлэлтийн дагуу үнэлдэг бөгөөд үүгээр дэлхий даяар гарч буй амьтны асуудлыг шийдвэрлэдэг ба үүнд гэрийн тэжээвэр амьтны үзүүлэлт томоохон байр суурийг эзэлдэг.

Амьтныг хамгаалах тус индексээр амьтны эрхийг хамгаалах, харгис хэрцгий хандахтай тэмцсэн хууль тогтоомжтой эсэх, хөдөө аж ахуй эрхлэхэд амьтны эрхийг хамгаалсан зохицуулалт байгаа эсэх, гэрийн тэжээвэр амьтан, тэр дундаа эзэнгүй амьтны эрхийг хамгаалсан зохицуулалт байгаа эсэх, энтертайнмент үйл ажиллагаа эрхлэхэд амьтны эрхийг хамгаалах зохицуулалт байгаа эсэх, амьтны эрхийг хамгаалахад төрийн байгууллагын оролцооны түвшин, ДЭМБ-ын амьтны эрхийг хамгаалах стандартыг баримталдаг эсэхийг гол шалгуур үзүүлэлт болгодог байна. Уг байгууллагад Ойрх Дорнодын дийлэнх улсууд, Ази тивээс Монгол Улс болон бусад цөөн улсын мэдээлэл байхгүй байна.

Олон улсын хэмжээнд эх газрын амьтантай холбоотой харилцааг Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын “Газрын амьтны эрүүл мэндийн кодекс”-р зохицуулсан. Монгол улс гишүүн орны хувьд тус байгууллагын олон улсын стандарт, зөвлөмжийг уялдуулан хэрэглэдэг. Энэхүү кодексийн 3.4.10-р зүйлийн 2 дахь хэсэгт гишүүн орны амьтны эмнэлгийн хууль тогтоомж нь чөлөөтэй тэнүүчлэх нохой, хаягдсан гэрийн тэжээвэр амьтныг орхихыг хориглох, хаягдсан амьтантай холбоотойгоор амьтныг шилжүүлэх, амьтны эмнэлгийн хөндлөнгийн оролцоо, эвтанази хийх зэрэг харилцааг зохих ёсоор зохицуулахыг зөвлөмж болгожээ.

Зарим улс амьтныг харгислахаас хамгаалах тухай хуультай бөгөөд энэ нь амьтныг шинжлэх ухааны туршилтад харгис аргаар ашиглах, нохой зодолдуулан бооцоо тавих, амьтны хүрээлэнд хүчирхийлэх асуудал нийтлэг байдагтай холбоотой. Гэрийн тэжээвэр амьтантай холбоотой эрх зүйн орчин таатай улс орнуудын хувьд амьтны эрхийг албан ёсоор хуулиар баталгаажуулсан байна. Тухайлбал, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Швейцарь, Австри Улсад амьтныг эд юмстай адилтгах боломжгүй гэж тусгай эрх зүйн чадварыг хуулиар хүлээн зөвшөөрч эрхийг нь баталгаажуулсан байдаг. Мөн тухайлан гэрийн тэжээвэр амьтныг тусгай эрх зүйн чадвартай гэж үзсэн улсын тоонд Бүгд Найрамдах Солонгос Улс орж байна.

Монгол Улсын хувьд нүүдлийн мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэх бодлого баримталдаг бөгөөд мал, ан амьтны үр шимийг хүртэж, түүхий эдийг нь боловсруулах замаар бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг тул мал, ан амьтныг “өмч” гэж үзэх үндэслэлтэй юм. Үүнийг Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Мал сүрэг бол үндэсний баялаг мөн...”, мөн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...ан амьтан төрийн нийтийн өмч мөн.” гэж заажээ.

Харин гэрийн тэжээвэр амьтнаас үр шим хүртэх боломжгүй бөгөөд хүн нохой, муур болон тэдэнтэй адилтгах бусад амьтныг “гэр бүлийн гишүүн” гэж үзэх, “найз” гэж харах хандлагатайгаар эрүүл мэндийн болон сэтгэл санааны эерэг нөлөөг нь онцлон тэжээдэг тул эд юмстай адилтгах үндэслэлгүй юм. Монголчууд нохойг мал сүргийг хариулах, хашаа хороогоо мануулах зорилгоор тэжээж ирсэн ч сүүлийн жилүүдэд хотжих үйл явц эрчимжсэнээс үүдэн нохой, муур болон бусад гэрийн тэжээвэр амьтныг тэжээх, үржүүлэх тохиолдол өсөн нэмэгдэж байна. Үүнийг дагаад гэрийн тэжээвэр амьтантай холбоотой харилцааг суурин соёл иргэншилтэй улс орны жишгээр тухайлсан хуулиар зохицуулах шаардлага бий болжээ.

Дэлхийн хүн ам, өрхийн орлого, амьжиргааны түвшин, тасралтгүй өсөх хотжилтын үйл явцын нөлөөгөөр гэрийн тэжээвэр амьтадын тоо урьд өмнө байгаагүйгээр асар хурдацтай өсөж байна. Хамгийн нийтлэг гэрийн тэжээвэр амьтан болох нохой 2012 онд дэлхийд 525 сая орчим байгаа гэж тооцож байсан бол 2020 онд энэ тоо 900 сая болж өссөн. Эдгээрээс 470 сая орчим нохой эзэнтэй байдаг. Харин муурын хувьд 2021 онд дэлхий дээр 600 сая гаруй муур амьдарч байгаагаас 370 сая орчим муур эзэнтэй байна. Үүнийг дагаад гэрийн тэжээвэр амьтны хоол хүнс, эд хэрэгслийн худалдаа, үйлдвэрлэл, үржүүлгийн бизнес хурдацтай өсч байна.

Монголын маркетингийн судалгаа ассоциаци (MMCG)-с 2021 онд хийсэн гэрийн тэжээвэр амьтны талаарх судалгаагаар Улаанбаатар хотод орон сууцны хороололд 21.7 мянга орчим, гэр хороололд 77.2 мянга орчим нохой тоологдсон бөгөөд нийт 98.8 мянган өрх нохой тэжээдэг гэсэн тоо гарчээ. Харин орон нутагт гэрийн тэжээвэр амьтны статистикийг нэгтгэн гаргасан тоо одоогоор байхгүй байна.

Хотжилтыг даган гэрийн тэжээвэр амьтны тоо толгой өсөхтэй холбоотойгоор хөгжиж буй болон хөгжил буурай улс орнуудад олон сорилт тулгарч байна. Тухайлбал, иргэдийн гэрийн тэжээвэр амьтан тэжээх мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, эзэнгүй амьтны тоо толгой өсөхтэй холбоотойгоор зоонозын халдварт өвчин, хөрсний болон агаарын бохирдлыг бууруулах, гэрийн тэжээвэр амьтныг тарчлаан зовоох, хүчирхийлэх, зүй бусаар үржүүлэхтэй тэмцэх асуудал тулгамдаж байна.

Монгол Улсад гэрийн тэжээвэр амьтан тэжээж буй иргэдийн мэдлэг, ур чадвар сул байдаг. Үүний улмаас халдварт /зооноз/ өвчний тархалт өсөх, бусдын бие махбодид хохирол учрах тохиолдол ихсэх, хяналтгүйгээр үржүүлэх, эзэнгүй амьтны тоо толгой өсөх үр дагавар бодитой бий болоод байна. Иймд гэрийн тэжээвэр амьтантай холбогдож үүссэн нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хөрсний болон агаарын бохирдлын асуудлыг шийдвэрлэх эрх зүйн орчин шаардлагатай байна.

## **1.2. Практик шаардлага**

### **а. Эздийн хариуцлагагүй байдал**

Гэрийн тэжээвэр амьтантай холбоотой нийгэмд үүсч буй олон асуудал амьтны эзэн буюу асран хамгаалагч, түр харагчийн хариуцлагатай шууд холбоотой байдаг. Иймд гэрийн тэжээвэр амьтныг тэжээхтэй холбоотой үүрэг, хариуцлагыг тодорхойлох шаардлагатай юм. Тухайлбал, олон нийтийн газар, хүүхдийн тоглоомын талбайд нохойг зориулалтын хөтөлгөө, хошуувч, цээживчтэй авч яваагүйгээс үүдэж бусдын бие махбодид хохирол учруулсан тохиолдлууд түгээмэл гарч байна.

2020 онд Монгол Улсын хэмжээнд нохойд хазуулсан шалтгаанаар осол, гэмтэлд өртөж, эмнэлгийн байгууллагад хандсан нийт 3,855 тохиолдол бүртгэгдсэн байна. Хүн рүү дайрсан нохдын 90% нь **эзэнтэй нохой** байжээ. Нохойд хазуулсан шалтгаанаар гэмтсэн хүмүүсийг насны бүлгээр авч үзвэл 37% нь 0-15 насны хүүхдүүд, тэр дундаа 5-9 насны хүүхдүүд гэмтсэн тохиолдол 17% эзэлж байна.

Түүнчлэн асран хамгаалагч, түр харагчид тухайн амьтныг тэжээх үүргээсээ зайлсхийж гудамжинд хаях, төөрүүлэх замаар эзэнгүй амьтны тоо толгойг нэмэгдүүлдэг. Мөн гэрийн тэжээвэр амьтныг тогтмол туулга, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад хамруулахгүй байх, олон нийтийн газар ялгадсыг

нь цэвэрлэхгүй байгаа нь мал, амьтнаас хүнд, эсхүл бусад амьтанд халдах халдварт өвчин тарах, хөрсний бохирдол үүсэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Иймд нохой, муурыг иргэний нэр дээр бүртгэх, тэдгээрийн үржлийг хязгаарлах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад хамруулах үүргийг гэрийн тэжээвэр амьтан асран хамгаалагчид хүлээлгэх замаар нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах шаардлагатай байна.

#### **б. Зооноз буюу амьтнаас хүнд халдах өвчин**

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас өнгөрсөн хугацаанд Монгол Улсад амьтнаас хүнд халдах өвчнийг бууруулах талаар анхааруулгыг удаа дараа ирүүлсэн. Тодруулбал, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас Тогтвортой Хөгжлийн 3 дахь зорилтын хүрээнд 2021-2030 он хүртэл “neglected tropical diseases” буюу анзаарагддаггүй өвчнийг бууруулах зорилтыг тавьж ажиллаж байгаа ба энэ асуудлаар манай улсын Эрүүл мэндийн яам болон Зоонозын өвчин судлалын үндэсний төвд анхааруулга ирүүлсэн.

Нохойноос хүнд халдварлах боломжтой 300 гаруй зоонозын халдварт өвчин байдгаас хамгийн ноцтой нь галзуу өвчин бөгөөд нийт тохиолдлын 99% нь нохойноос хүнд халдварладаг. Дэлхийд жилд дунджаар 60,000 хүн галзуу өвчний вирусийн нөлөөгөөр амиа алддаг байна.

“Вай инсайт” ХХК-с 2021 онд хийсэн судалгаагаар Монгол Улсад гэрийн тэжээвэр амьтнаас хүнд халдварладаг галзуу, бэтэг, мөөгөнцөр зэрэг зоонозын өвчин хамгийн түгээмэл байдаг. Нохойноос галзуу, бэтэг, лептоспироз зэрэг өвчнүүд хүнд халдварладаг бол муураас мөөгөнцөр, токсоплазмоз, галзуу зэрэг зоонозын өвчин элбэг халдварладаг байна.

Галзуу өвчнөөр жилд дунджаар 250 орчим нохой, 10 муур үхдэг гэж Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн мэргэжилтнүүд мэдээлсэн. Улаанбаатар хотын хэмжээнд 2020 онд гэр хорооллын айл өрхийн 3,000 нохойнд санамсаргүй түүвэрлэлтээр дээж авч үзэхэд 145 буюу 5%-д нь бэтэг өвчин үүсгэгч, 398 буюу 13%-д нь бусад шимэгч хорхой бүртгэгдсэн байна.

Хүнд халдварлах эрсдэл бүхий зооноз халдварт, галзуу өвчний тохиолдол гэрийн тэжээвэр амьтанд 2016 онд 2, 2017 онд 3, 2018 онд 1, 2019 онд 1, 2020 онд 1 тус тус бүртгэгдэж, 5-7 жилд 1 хүн нас бардаг бол бэтэг, мөөгөнцөр өвчнөөр өвчилсөн хүн болон нас барж буй хүний тоо бүрэн гардаггүй байна. Галзуу өвчний эрсдэлд өртсөн хүнд 3-4 тун вакцины зардал гарах бол бэтэг өвчин туссан үед эмчилгээний зардал 10 орчим сая төгрөг хүрдэг байна.

Иймд гэрийн тэжээвэр амьтанг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад хамруулах, туулга уулгах үүргийг гэрийн тэжээвэр амьтан асран хамгаалагчид хүлээлгэх шаардлагатай байна.

#### **в. Хяналтгүй үржүүлэг**

Монгол Улсад 1000 гаруй үржүүлгийн газар нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа явуулдаг байна. Мал, эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны А/08 дугаар тушаалаар батлагдсан “Хот суурин газрын нутаг дэвсгэрт мал,

амьтан, тэдгээрийн гаралтай хүнсний бус түүхий эдийн худалдаа эрхлэхэд тавигдах мал эмнэлэг, ариун цэврийн шаардлага"-ын 5 дугаар зүйлд үржүүлэх газар, түр асрах байрны эрүүл ахуйн шаардлагыг заасан боловч иргэд нохой, муурыг зүй бусаар үржүүлсээр байна. Үүнээс болж хариуцлагатай үржүүлэгчдийн эрх ашиг зөрчигддөг бөгөөд нохой, муур үнэ цэнгүй болж, эрүүл мэндийн асуудалтай гэрийн тэжээвэр амьтан худалдах нөхцөл бүрджээ.

Үржүүлэгчдийн хувьд гэрийн тэжээвэр амьтныг ашиглан аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж, ашиг олох зорилготой байдаг учраас улс орнууд тухайн амьтны амь нас, эрүүл мэндийг хамгаалсан үржүүлгийн нийтлэг шаардлагыг хуульчилсан байдаг. Тухайлбал, нохойны ороо жилд 2-3, муурын ороо жилд 3-4 ордог боловч нохой, муурын эрүүл мэндийг хамгаалахын тулд жилд нэг л удаа нийлүүлэх шаардлага тавьдаг байна.

Харин манай улсад үржүүлгийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, үржүүлэгчийн бүртгэл, зөвшөөрлийг хуулиар зохицуулаагүй тул иргэд эрүүл ахуйн шаардлага хангаагүй орчин нөхцөлд нохой, муурыг ороо орох бүрт нь үржүүлснээр эрүүл мэндийн асуудалтай болон эзэнгүй амьтны тоо толгой өссөөр байна. Мөн үржүүлсэн нохой, муурын үр төлийг худалдахад ямар нэг шаардлага тавигдаагүйгээс амьтныг хөдөлгөөн хязгаарласан дэлгүүрийн орчинд "эд бараа" мэт байрлуулж, худалдах явдал түгээмэл байна.

Хариуцлагагүй үржүүлэг нь цаашлаад хариуцлагагүй худалдан авах нөхцөлийг үүсгэдэг. Өөрөөр хэлбэл, амьтан тэжээхэд шаардлагатай мэдлэггүй амьтан тэжээгчдийн тоо нэмэгдэх, амьтан хаягдаж гудамжинд гарах үр дагавар бий болдог байна.

Иймд нохой, муур үржүүлэх үйл ажиллагааг гагцхүү зөвшөөрөл авсан үржүүлэгч эрхлэх хэрэгтэй бөгөөд тэдгээрийн бүртгэл, үйл ажиллагаанд нь тавигдах шаардлага, хариуцлагыг хуулиар зохицуулах шаардлагатай юм. Үүний үр дүнд зүй бус үржүүлэг зогсох, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эзэнгүй нохой, муурын тоо толгойг бууруулах боломж бүрдэнэ.

#### **г. Эзэнгүй амьтны тоо толгой**

Нэг хос нохой, муур нь 6 жилд 67,000 болж үрждэг байна. Хариуцлагагүй иргэд, үржүүлэгч нарын улмаас Монгол Улсад эзэнгүй, нохой, муурын тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Улаанбаатар хотын хэмжээнд 320 мянга гаруй эзэнгүй нохой, мууртай гэсэн албан бус тоо байдаг бөгөөд нохой, муурыг албан ёсоор бүртгэж, тооллого хийдэггүй юм.

Эзэнгүй нохой, муурын тоо өсөх нь гэрийн тэжээвэр амьтан тэжээж буй иргэдийн хариуцлагагүй байдал, гэрийн тэжээвэр амьтнаа хаях, төөрүүлэх, үржил хязгаарлах мэс ажилбар хийлгэхгүй байх, түүнд хариуцлага тооцох, хянах хууль эрх зүйн орчин байхгүйтэй холбоотой байна.

Эзэнгүй нохой, муурын тоо толгойг бууруулахтай холбоотой Улаанбаатар хот, Дархан-Уул аймаг, Дундговь аймагт мөрдөгдөж байгаа тухайн орон нутгийн өөрөө удирдах байгууллагаас баталсан журам нь хангалттай, үр дүнтэй үйлчлэхгүй байгаагаас төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагддаг. Нийслэлийн

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 6/11 дүгээр тогтоолоор 1 нохой, муур устгах зардлыг 12,000 төгрөг байхаар тогтоосон бөгөөд 2021 онд зөвхөн Улаанбаатар хотод эзэнгүй нохой, муурыг устгахад 1,2 тэрбум төгрөг төсөвлөжээ. Нийслэлийн Захирагчийн ажлын албаны мэдээлснээр жилд 100 мянган эзэнгүй нохой, муур устгахаар төлөвлөдөг бөгөөд гүйцэтгэлээр жилд дунджаар 80-90 мянган эзэнгүй нохой, муур устгадаг байна. Гэвч үлдсэн 220 гаруй эзэнгүй нохой, муур жилд 2,3 дахин нэмэгдсээр байх тул ингэж өндөр өртгөөр устгал хийх нь үр дүнгүй юм.

Эзэнгүй амьтны тоо толгой нэмэгдсэнээр амьтнаас амьтанд болон хүнд халдах халдварт өвчин хурдацтай тархаж, догшин зан авиртай ноход ан амьтан, эзэнтэй мал, амьтан, хүн рүү дайрах тохиолдол нэмэгдэх нөхцөл болдог. Түүнчлэн устгасан нохой, муурын сэг зэмийг хөрсөнд булснаар хөрсний бохирдол, халдварт өвчин тарах гол нөхцөл болж байгааг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас сануулсан байна.

Ийнхүү эзэнгүй нохой, муурыг галт зэвсгээр устгах нь улсын төсөвт дарамт болж байгаагаас гадна тэдгээрийн тоо толгойг бууруулах үр дүнтэй шийдэл болж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл, асуудлыг үүсгэж буй шалтгаан, нөхцөлийг хуулиар зохицуулахгүйгээр эзэнгүй амьтны тоо толгойг бууруулах боломжгүй юм. Иймд уг асуудлыг бодитойгоор шийдвэрлэх эрх зүйн орчин нэн шаардлагатай байна.

#### **д.Гэрийн тэжээвэр амьтны эсрэг хүчирхийлэл**

Монгол Улсад эзэнгүй нохой, муурын тоо толгойг бууруулахад хэрэглэж буй үндсэн арга нь галт зэвсгээр буудах бөгөөд үр дүнгүй олон жил амьтныг харгислах нөхцөл бий болгожээ. Тухайлбал, нохой, муурыг олон нийтийн газар, гудамж талбайд буудахдаа хүний эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах, нохой, муурыг дутуу буудах, савж алах, бага насны хүүхдийн болон гадны жуулчдын нүдэн дээр устгах, тэдний сэтгэл зүйд сөрөг нөлөөлөл үзүүлэх, устгалын тоо зааж энгийн иргэдэд мөнгө өгч зүй бус аргаар устгуулах зэрэг асуудал түгээмэл байна.

Иргэдийн зүгээс гэрийн тэжээвэр амьтантай зүй бусаар харьцаж, амьтны зан араншинг догшруулдаг. Үүнээс гадна нохойг зориулалтын бус хэт богино уяанд уяж, хөдөлгөөнийг нь цаг үргэлж хязгаарлах, өлсгөх, цангаах, хүйтэнд үүргүй байлгах, зодох, эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх, хараа хяналтгүй удаан хугацаагаар орхих, хооронд нь зодолдуулах, өгөөш бай болгох, үр төлийг нь гаргаж хаях, төөрүүлэх, химийн бодис, согтууруулах ундаа, сэтгэцэд нөлөөлөх бодисоор хордуулах, нохой, муурыг ашиглан бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах зэрэг олон хэлбэрээр гэрийн тэжээвэр амьтныг хүчирхийлдэг байна.

Дээрх хүчирхийллийн хэлбэрүүд бага насны хүүхэд болон насанд хүрсэн иргэдийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлдөг бөгөөд амьтан, хүнтэй зүй бусаар харьцах сэдлийг өдөөж байдаг. Гэрийн тэжээвэр амьтныг хүчирхийллээс хамгаалах замаар амьтныг хайрлах, энэрэнгүй хандах, хамгаалах төлөвшлийг иргэдэд бий болгосноор хариуцлагатай иргэн гэрийн тэжээвэр амьтан асран

хамгаалах нөхцөл бүрдэх ач холбогдолтой байна. Иймд гэрийн тэжээвэр амьтны хүчирхийлэл гэж үзэх үйлдлийг хуулиар тодорхойлон зохицуулах шаардлагатай байна.

**Хоёр. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль эрх зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Хуулийн төсөл батлагдснаар гэрийн тэжээвэр амьтантай холбоотой суурь харилцаа зохицуулалттай болж, гэрийн тэжээвэр амьтны асран хамгаалагч, түр харагчийн эрх, үүрэг, үржүүлэгч, түр байрлуулан асрамжлах газарт тавигдах шаардлага, тэдгээрт хүлээлгэх хариуцлага тодорхой болох бөгөөд хяналтгүй үржүүлэг, эздийн хариуцлагагүй байдлаас үүдэлтэй эзэнгүй нохой, муурын тоо толгой өсөх нөхцөлийг бодитой бууруулах нөхцөл бүрдэнэ. Түүнчлэн төсвөөс нохой, муурын устгалд зарцуулагдаж буй зардлыг хэмнэх боломжтой юм.

Нохой, муур үржүүлэх үйл ажиллагааг ашгийн төлөө хуулийн этгээд зөвшөөрөл авч эрхлэхээр хуулийн төсөлд туссан. Иймд татвар төлөхгүйгээр нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа албан бусаар эрхэлж ашиг олж байгаа этгээдүүд ашгийн төлөө хуулийн этгээдийн хэлбэрээр үйл ажиллагаа эрхэлснээр холбогдох хууль тогтоомжид заасны дагуу борлуулалтын орлого болон бусад шаардлагатай мэдээллийг тайлагнах, хуульд заасан хувь хэмжээгээр албан татвар төлөх үүрэг хүлээнэ. Ийнхүү албан бус эдийн засаг дахь нохой, муур үржүүлэх үйл ажиллагааг зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагаа болгосноор улсын төсөвт төвлөрөх татвар нэмэгдэх боломжтой гэж үзэж байна.

Ийнхүү уг хуулийн төслөөр зоонозын халдварт өвчин, агаар болон хөрсний бохирдол, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж буй нөхцөл байдлыг үүсгэж буй харилцан холбоо бүхий асуудлыг сууриар нь шийдвэрлэх боломж бүрдэнэ гэж хууль тогтоогчийн хувьд үзэж байна.

**Гурав. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг сайжруулах зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Амьтны тухай хууль, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нийцсэн. Хуулийн төсөлтэй уялдуулан Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Статистикийн тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Татварын ерөнхий хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах, Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг шинээр боловсруулах шаардлагатай байна.

---oOo---